

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
“ИННОВА ЛОЖИСТИК” ХХК**

**2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

## **2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГА**

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ, ЗӨВЛӨМЖ
3. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ, ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
8. ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР
10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
11. БОМТ-ИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

## КОМПАНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 НЭР

“Шийрийн хөндийн адаг-4 шохойн чулууны уурхай”

### 1.2 ЗОРИЛГО

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт Шийрийн хөндийн шохойн чулууны уурхайг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар ашиглахад төслийн зорилготой оршино.


### 1.3 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН НЭР

“ИННОВАЛОЖИСТИК” ХХК

### 1.4 БАЙРШИЛ

Дархан уул аймгийн Хонгор сумын Шийрийн хөндийд 25 га талбай бүхий газар, Хонгор сумаас хойш 20 орчим км зайд байрладаг

## ҮЙЛДВЭРИЙН ТЕХНОЛОГИ ЗУРАГ



**а) Үйлдвэрийн танилцуулга**

- “Инноваложистик” ХХК нь 2014 оны 05-р сард Шохойн чулуу баяжуулах үйлдвэрт шохой шатаах үндсэн чиглэлтэйгээр ашиглалтанд орсон .
- Жил бүр татвар төлдөг, татвар төлөгч байгууллага юм.
- Одоогийн байдлаар нийт 15 ажилтан албан хаагчидтай, ажиллах хүчний 80 гаруй хувь нь 25-40 насны иргэд байдаг.
- Дархан-Уул аймгийн Дархан сумын Шийрийн хөндийт 25 га газрыг АМХЭГазрын ГУУКАлбанаас олгосон 5655А дугаартай ашигт малтмал ашиглах лицензийн гэрчилгээнд тусгагдсан талбайд үйл ажиллагааг явуулж байна.

**б) Төслийн хүчин чадал**

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дэсвгэр дэх Шийрийн хөндийн адагт орших шохойн чулууны 4-р ордод 1986-1993 онуудад олборлолт явуулж эхэлсэн. Нарийвчилсан хайгуулын ажлыг ЗХУ-ийн геологийн хайгуулын анги хийж 1962онд тус 4-р ордын нөөцийг С2 - 508.3мян.тн хэмжээтэйгээр тогтоосон байна. Ашиглалтын үед нийт геологийн нөөцөөс 280.2мян.тн-ийг ашиглаж. 34.1мян.тн-ийг ул, тааз, чулуулга үеийн бохирдолтоос овоолгод 337.1мян.тн-ийг үйлдвэрт ашиглах агуулга хангахгүй учир овоолгод хаясан байна. Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг Шийрийн хөндийн адаг дахь 4-р ордын ухсан карьерийн хэсгийг үргэлжлүүлэн ашиглах явцад ордын нөөцийг нэмэгдүүлэх. олборлолтоос гарах шохойн чулууг хэрэгцээт газарт нийлүүлэхээр төлөвлөсөн байна. 2003 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр 1023т/м өрөмдлөг явуулж 6400 м3 уулын цул тэслэж 4925тн хадан хөрс хуулан. Үүнээс 10.000тн шохойн чулуу олборлохоор тусгажээ.

**1. Инженерийн байгууламж:**

**Тээвэрлэлт :**

- Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу жилд хамгийн ихдээ 117,4 мян.м3 хөрс хуулж, 50,0 мянган тн шохойн чулуу олборлоно
- Уулын ажлаар хуулах хөрсийг гадаад овоолгын талбайд тээвэрлэнэ. Хөрсний тээврийн зай дундажаар 0,6 км болно. Мөн дөрөвдөгч худаснаас үржил шимт хөрсийг хуулан зурагт үзүүлсний дагуу овоолно.

- Шохойн чулууг агуулахын талбай хүртэл 0,6 км зайнд тээвэрлэнэ.
- Уурхайн гадаад вээврийн зам шийрийн хөндийн шохойн чулууны ил уурхайгаас олборлосон шохойн чулууг уурхайн дэргэдэх тоосго шатаах баюунд шатаах

**Цахилгаан хангамж:**

- Шийрийн хөндийн шохойн чулууны орд нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших бөгөөд Хонгор сумын төвөөс өндөр хүчдлийн цахилгаан шугамаар цахилгаан эрчим хүчээр хангагдаж байгаа.

**Зам байгууламж:**

- Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших “Шийрийн хөндийн шохойн чулууны орд” газар нь Дархан сумаас зүүн урагш 4,5 км, Улаанбаатар хотоос 236 км зайтай оршдог. Улсын чанартай авто болон төмөр замын 11 км орчим алслагдсан бөгөөд эдгээр замуудад сайжруулсан шороон замаар холбогдоно.

## **2. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ**

- Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдал, хүний эрүүл ахуйд нөлөөлж болох сөрөг нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүгнэлтүүд дээр үндэслэн тэдгээрээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгахад энэхүү үнэлгээний гол зорилго чиглэгдэнэ.
- Тус үйлдвэр нь өөрийн техник, технологио үйлдвэрлэлийн хүчин чадал, эдийн засгийн боломжтойгоо уялдуулан байнга шинэчилж илүү дэвшилтэт, байгаль орчинд хал багатай технологиор экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой юм. Гэвч аливаа үйлдвэрлэл нь байгаль орчин болон ажиллагсдын эрүүл мэндэд тодорхой хэмжээгээр сөрөг нөлөөлөл үзүүлдэг билээ. Үүнд:
- Үйлдвэрлэлийн технологийн дамжлагуудын онцлогоос шалтгаалан гарах хатуу, тоос шороо, бичил орчны температур, чийгшил, гэрэлтүүлэг,
- Болзошгүй осол аваар, саатал, техник, технологийн шугам сүлжээний гэмтэл, гал, усны гэнэтийн аюул;
- Ус, цахилгаан болон түүхий эд, туслах материал зэргийн хангамжийн саатал, өөрчлөлт зэрэг үйлдвэрлэлийн болон удирдлагын үйл ажиллагаанаас үл шалтгаалах нөлөөллүүд сөрөг нөлөөлөлд хамаарна.
- “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-д аж ахуйн нэгж бүр үйлдвэрлэлийн үед гарч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг жил бүрийн төсөл (үйлдвэр-санхүүгийн) төлөвлөгөөндөө тусгаж ажиллах нь зүйтэй гэсэн зүйл заалттай. Иймээс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлж байхыг зөвлөж байна.

## **3. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг баталгаатай байлгах үндэслэл болдог.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчны хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартуудын дагуу төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх болзошгүй болон голлох сөрөг

нөлөөллийг бууруулахын тулд авах арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгө зардлуудыг тооцон гаргасан.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг компанийн удирдлага тухайн жилийн үйл ажиллагааныхаа зардалд тусган төлөвлөж зарцуулж байх нь зүйтэй. Бидний боловсруулсан байгаль хамгаалах төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах байгалийн нөөц баялагийг зүй зохистой ашиглах боломж бүрдэхээс гадна төслийн хэрэгжих чадварыг дээшлүүлж, эдийн засгийн үр ашиг нэмэгдэнэ.

- Үйлдвэрийн ажилчдын ажиллах нөхцөл байдлыг хангах, байнга хяналт шалгалт хийх. Хог хаягдлыг удаан хугацаагаар хадгалахгүй байх, гэрээний дагуу хугацаанд нь зайлуулах
- Газрын хэвлий болон байгаль хамгаалах, ашигт малтмалын тухай хуулиудын холбогдох заалтуудыг эрэл хайгуулах болон ашиглалтын явцад чандлан мөрдөх
- Эрэл хайгуулын суваг, цооног, шруп малтмал зэргийг гүйцэтгэсний дараа ашиглахгүй үлдсэн хэсгийг эргүүлэн буулж тэгшлэн нөхөн сэргээлт хийх
- Олборлолтын явцад болон олборлолтын дараа тус талбайд үүссэн нүх, карьер хүн ард, мал амьтан унахааргүй байхаар ахмгаалах бүрэн хэмжээнд нөхөн сэргээх шаардлагатай
- Агаарын бохирдол болон бусад үзүүлэлтүүдийн шинжилгээг жилд 1 удаа байнга авч шинжлүүлэх. Ялангуяа тоос, дуу чимээ гэх мэт үзүүлэлтүүдийг нарийн тодорхойлуулах. Тос тослох материалыг хөрсөнд нэвчихээр ил задгай хаяхгүй байх. Техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах, тогтмол хяналт шалгалт хийх.
- Ургамалжуулж бут сөөг тарихдаа химийн гаралтай бодис бордоо хэрэглэхээс аль болох татгалзах.
- Ургамалжуулах зүлэгжүүлэхдээ мэргэжлийн байгууллагын заавар, зөвлөгөөг авч ажиллах.
- Үйлдвэрийн хаягдлыг байгаль орчинд халгүй болгон зайлуулах.
- Ахуйн хог хаягдлын цэгийг 3х4м-ийн харьцаатай бетонон суурьтай 3 ангилалтай байхаар байгуулах

- Хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын сав баглаа боодлоор боож, төрөлжүүлэн зайлуулах
- Агаарт үүсэх тоосны бохирдол болон дуу чимээний бохирдлыг багасгах, арилгах талаар арга хэмжээ авч, багасч буй тал дээр анхаарч байнга судалгаа хийх.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг жил бүр гүйцэтгэж, тухай бүр нь батлуулан хэрэгжүүлж ажиллах.
- Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар тус тайлангийн бүлгүүдэд тусгасан заалт зөвлөмжүүдийг биелүүлж ажиллах арга хэмжээг авах

### **Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хууль зүйн үндэс**

Монгол улсын "Байгаль орчныг хамгаалах тухай", "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай", "Газрын тосны бүтээгдэхүүний тухай", "Газрын тосны тухай", "Галын аюулгүй байдлын тухай", "Хэмжилтийн нэгдмэл байдлыг хангах тухай", "Ариун цэврийн тухай", "Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай", "Химийн хорт бодисоос хамгаалах тухай", "Авто тээврийн тухай" хуулиуд болон Засгийн Газар, БОАЖЯ болон бусад яамнаас гаргасан холбогдох заавар журмын дагуу боловсруулав. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн байгаль орчныг хамгаалах талаар хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан бөгөөд одоогийн төлөвлөсөн хүчин чадлын хэмжээнд үйл ажиллагаа явуулах хугацаанд уг төлөвлөгөө хүчин төгөлдөр байна.

- Байгаль орчин, техник технологийн асуудал
- Төслийн үндсэн үйл ажиллагаа

Төслөөс гарах хаягдлыг хадгалах, зайлуулах, орчны бохирдлыг багасгах, гал түймэр болон бусад осол аюулаас сэргийлэх арга технологийг тайлангийн зохих хэсгүүдэд тусгасан болно.

- Байгаль орчин-нийгэм, эдийн засгийн асуудал

Төсөл хэрэгжсэнээр орон нутгийн иргэд ажлын байраар хангагдахын зэрэгцээ орон нутгийн төсөвт тодорхой хувь нэмэр оруулна.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээх, байгаль хамгаалах зардлыг тус компани өөрийнхөө үйл ажиллагааны зардалд оруулан тооцож байна.

Байгаль орчин-Удирдлага зохион байгуулалтын ажил

Тус төслийн өмнөх байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан болон төслийн талбайд хийсэн хээрийн судалгаа, шинжилгээний дүн зэргийг үндэслэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг боловсруулав. ТЭЗҮ-д тусгагдснаар уурхай ойролцоогоор 26 жил ажиллах болно. Мөн уурхайн уул-техникийн ажлын нөхцөл зэргийг харгалзан үзвэл нөхөн сэргээлтийг уурхайг ашиглаж дуусны дараа хийхээр байгаа тул ашиглалтын явцад байгаль хамгаалах болон дүйцүүлэн хамгаалалын ажлыг сайтар хийж байх нь зүйтэй болно. Энэ нь уурхайн ажиллагаа дуусны дараа нөхөн сэргээлт хийгдэхтэй холбоотой юм.

Энэхүү төлөвлөгөөний дагуу 2021-2025 оны хооронд болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөллүүдээс сайтар сэргийлэн ажиллах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэх, хог хаягдлын сайтар бэлтгэгдсэн менежмент, зайлуулах устгах системтэй болох зэрэг байх болно.

☐ Уурхайн дотоод үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилтийг бууруулах ☐ Болзошгүй эрсдэл, хүчиллэг урсац бүхий үерийн үед ажиллах төлөвлөгөөтэй болох

☐ Хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах, устгах системийг бий болгох

☐ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэх

☐ Үйл ажиллагааны явцад учирч болзошгүй эрсдэл аюулаас бүрэн сэргийлж ажиллах, энэтэй холбоотой сургалтыг тогтмол зохион байгуулах

☐ Байгаль хамгаалах төлөвлөгөө болон үнэлгээний тайлангийн хүрээнд хэрэгжилтэнд 2 жил тутамд байгаль орчны аудитын тайланг хийлгэх

#### **4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Тус төлөвлөгөөний гол зорилго нь дээр тодорхойлсон голлох сөрөг нөлөөллүүдийг бууруулах оршино. Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа дээрх төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлийн товч тодорхойлолт болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт зэргийг үндэслэн хийв. Зардлын хэмжээг 1 жилээр гаргав.

Хүснэгт 1

| #                    | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ                                                                                                                                      | Хамрах хүрээ                       | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ төг    | Нийт зардал төг     | Хэрэгжүүлэгч      | Хамтран хэрэгжүүлэгч                                   | Биелэлтийн шалгуур                               | Баримтлах хууль, журам, стандарт   |
|----------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------|-------------|------------|------------------------|---------------------|-------------------|--------------------------------------------------------|--------------------------------------------------|------------------------------------|
| 1                    | Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх                                                                                              | Ил уурхай                          | м³/сар      | Жил бүр    | 6 600 000              | Иннова Ложистик ХХК | -                 | -                                                      | Шаардлагатай нөхцөлд усалгаа хийгдсэн байх       | Агаарын тухай хууль, MNS 4585:2007 |
| 2                    | Уурхайн технологийн замын засвар үйлчилгээг тогтмол хийж үүсэх тоосжилтын хэмжээг бага байлгах                                                                            |                                    | м³          |            | Үйлдвэрлэлийн зардлаас |                     | -                 | -                                                      | Замын засвар үйлчилгээ тухай бүр хийгдсэн байх   |                                    |
| 3                    | Уурхайн тээврийн машины хурдны хязгаарт хяналт тавьж, үүсэх тоосыг бага байлгах                                                                                           |                                    | -           | Өдөр бүр   |                        |                     | -                 | -                                                      | Машины хурд тогтоосон хязгаараас хэтрээгүй байх. |                                    |
| 4                    | Техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг хянаж, техникийн хэвийн ажлын горимыг ханган тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах хийг үйлдвэрлэгчээс гаргасан хэм хэмжээнд байлгах | Төслийн талбайн хөнгөн тэрэгнүүд   | ширхэг      | 10         | Үйлдвэрлэлийн зардлаас |                     | Байгаль орчны баг | Улсын үзлэгт хамрагдаж Холбогдох төлбөрийг төлсөн байх | АТ Хууль АБТТ Хууль                              |                                    |
| 5                    | Гадаад тээврийн замын арчилгааг байнга хийж байх                                                                                                                          | уурхайгаас Засмал зам хүртэл зам   | 80 км       | Тухай бүр  | Үйлдвэрлэлийн зардлаас |                     | Байгаль орчны баг | Шороон замаар тээвэр хийсэн тохиолдол гараагүй байх    | БОХТ Хууль                                       |                                    |
| 6                    | Агаарын тоосжилт буюу PM2.5, 10 хэмжигч 1 цэг байршуулах                                                                                                                  | Уурхайн хүрээ болон нөлөөллийн бүс | ш           | 1          | 5 000 000              |                     |                   |                                                        |                                                  |                                    |
| БОМТ-ний зардал, төг |                                                                                                                                                                           |                                    |             |            |                        |                     |                   | 11 600 000                                             |                                                  |                                    |

Хүснэгт 2

| # | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ                                                                                                                                       | Хамрах хүрээ                       | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ төг               | Нийт зардал төг        | Хэрэгжүүлэгч                                 | Хамтран хэрэгжүүлэгч   | Биелэлтийн шалгуур                                        | Баримтлах хууль, журам, стандарт     |
|---|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------|-------------|------------|-----------------------------------|------------------------|----------------------------------------------|------------------------|-----------------------------------------------------------|--------------------------------------|
| 1 | Түлш, шатах тослох материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих, асгаралт үүссэн талбайг цэвэрлэх, хөрсийг саармагжуулах арга хэмжээ авч ажиллана. | Төслийн талбай                     | удаа        | 12         | 100000                            | 1200000                | Байгаль орчны баг                            | Төслийн нэгжүүд        | Хөрсний шинжилгээний дүн стандартын шаардлага хангаж байх | ХХЦСТ Хууль, MNS 5850:2008           |
| 2 | Салаа зам үүсэхээс хяналт тавьж, хөрсний элэгдэл эвдрэл үүсэхээс урьдчилан сэргийлнэ                                                                                       | Төслийн талбай                     | хүн/өдөр    | 12         | 100000                            | 1200000                | Байгаль орчны баг                            | Төслийн нэгжүүд        | Төслийн нөлөөллөөр салаа зам гараагүй байх                | ХХЦСТ Хууль, ГТХууль                 |
| 3 | Хөрсний төлөв байдал ба бохирдлын мониторинг судалгаа хийж хэрэгжүүлэх                                                                                                     | Уурхайн орчмын бүс                 | Удаа        | 2          | Орчны хяалт шинжилгээний зардлаас |                        | Байгаль орчны баг                            | Мэргэжлийн байгууллага | Шинжилгээний дүн, Тайлан гарсан байх                      | БОНБУТХ MNS 5850:2008, MNS 3297:1991 |
| 4 | Үер болон борооны усаар зөөгдөн элдэв хог хаягдал хөрсөнд шингээгдэхээс сэргийлж үерийн ус зайлуулах суваг, шуудуу байгуулах                                               | Төслийн талбай болон түүний орчимд | -           | -          | -                                 | Үйлдвэрлэлийн зардлаас | Уулын үйлдвэрлэлийн хэсэг, байгаль орчны баг | Төслийн нэгжүүд        | Үйлчлэлийн нөлөөгөөр                                      |                                      |
| 5 | Зориулалтын хог шатаах зуух ашиглах                                                                                                                                        | Төслийн талбай                     | ш           | 1          | 25 000 000                        | 25 000 000             |                                              |                        |                                                           |                                      |
| 6 | Стандартын нийтийн бие засах газрыг бий болгох                                                                                                                             | Төслийн талбай                     | ш           | 2          | 5 000 000                         | 10 000 000             |                                              |                        |                                                           |                                      |

Хүснэгт 3

| #                        | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ                                                           | Хамрах хүрээ   | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ мян.төг | Нийт зардал мян.төг | Хэрэгжүүлэгч                      | Хамтран хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Баримтлах хууль, журам, стандарт |
|--------------------------|------------------------------------------------------------------------------------------------|----------------|-------------|------------|-------------------------|---------------------|-----------------------------------|----------------------|--------------------|----------------------------------|
| 1                        | Ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх                                      | Төслийн талбай | Удаа        | 1          | 3 000 000               |                     | Мэргэжлийн судлаач, байгууллага   | Байгаль орчны баг    | Тайлан гарсан байх | БОНБУТ Хууль                     |
| 2                        | Амьтны аймгийн мониторинг судалгааг том хөхтөн амьтан, шувууд зэрэг чиглэлээр хийж хэрэгжүүлэх | төслийн талбай | Удаа        | 1          | 2 000 000               |                     | Мэргэжлийн судлаачид, байгууллага | Байгаль орчны баг    | Тайлан гарсан байх | БОНБУТ Хууль                     |
| БОМТ-ний зардал, мян.төг |                                                                                                |                |             |            | 5 000 000.0 төгрөг      |                     |                                   |                      |                    |                                  |

### 5.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус уурхайн нийт 26 жил ашиглагдах бөгөөд уурхайлалт гүн рүүгээ явах тул ашиглалтын сүүлийн жилүүдэд техникийн сэргээн хийгдэх юм. Хэдий тийм боловч жил болгон нөхөн сэргээх боломжтой талбайг стандартын дагуу нөхөн сэргээх нь зүйтэй юм.

Хүснэгт 4

| Ажлын хэмжээ             | Хамрах хүрээ   | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ | Нийт зардал | Хэрэгжүүлэгч          | Хамтран хэрэгжүүлэгч                   | Биелэлтийн шалгуур | Баримтлах хууль, журам, стандарт |
|--------------------------|----------------|-------------|------------|-----------------|-------------|-----------------------|----------------------------------------|--------------------|----------------------------------|
|                          | Уурхайн талбай | овоолго     | -          | 5 900 000       |             | "Иннова Ложистик" ХХК | Нөхөн сэргээлтийн мэргэжлийн компаниуд |                    |                                  |
| Биологийн нөхөн сэргээлт |                | га          | 1          | 1 000 000       |             |                       |                                        |                    |                                  |
| Мод сөөг тарих           |                | ш           | 100 ш      | 2 000 000       |             |                       |                                        |                    |                                  |
| Нийт дүн                 |                |             |            | 8 900 000       |             |                       |                                        |                    |                                  |

### 6.БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Иннова Ложистик” ХХК-ний уурхайн орчинд биологийн олон янз байдлын судалгаа, шинжилгээ хийх, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тогтоох зөвлөх үйлчилгээний тайлан үндэслэн зардлын хэмжээг тогтоов.

#### Хийхээр төлөвлөж буй ажил

Дархан-Уул аймаг болон Хонгор сумын захиргаа болон холбогдох мэргэжлийн байгууллага дүйцүүлэн хамгаалах ажлын чиглэлийг жил бүр гаргаж

өгч байхаар тохиролцсон болно. Иймд төсөл хэрэгжүүлэгч Дархан-Уул аймгийн БОАЖГ-т дүйцүүлэн хамгаалах ажлыг хийх хүсэлтэй тавьж дүйцүүлэн хамгаалах ажлыг хийхээр болсон байгаа.

Хүснэгт 5

| Ажлын хэмжээ                              | Хамрах хүрээ       | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ | Нийт зардал | Хэрэгжүүлэгч          | Хамтран хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Баримтлах хууль, журам, стандарт |
|-------------------------------------------|--------------------|-------------|------------|-----------------|-------------|-----------------------|----------------------|--------------------|----------------------------------|
| Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал | Хонгор сумын нутаг | ш           | 1          |                 | 5 000 000   | "Иннова Ложистик" ХХК | -                    |                    |                                  |
| Нийт дүн                                  |                    |             |            |                 | 5 000 000   |                       |                      |                    |                                  |

## 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ, ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Хүснэгт 6

| Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ                                               | Хамрах хүрээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ төг | Нийт зардал төг | Хэрэгжүүлэгч          | Хамтран хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Баримтлах хууль, журам, стандарт                                        |
|------------------------------------------------------------------------------------|--------------|-------------|------------|---------------------|-----------------|-----------------------|----------------------|--------------------|-------------------------------------------------------------------------|
| Сумын тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалах үйл ажиллагаанд оролцож дэмжих | Хонгор сум   | ш           | 1          | 2 000 000           |                 | "Иннова Ложистик" ХХК | Сумын ЗДТГ           |                    | Байгаль орчин нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ, Түүх соёлын тухай хууль |
| НИЙТ ЗАРДАЛ, төг                                                                   |              |             |            |                     | 2 000 000       |                       |                      |                    |                                                                         |

## Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө


Хүснэгт 7

| №  | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл                       | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ                                                | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ          | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|----|------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------|----------------------------|---------------------|---------------------|------------------|--------------------------------|---------------------------------|
|    | 1                                                          | 2                                                                                         | 3                          | 4                   | 5                   | 6                | 7                              | 8                               |
| 1. | Уурхайн ажлын явц дахь болзошгүй осол                      | Анхааруулсан тэмдэг тавьж байрлуулах                                                      | Төслийн талбай             | 10                  | 40000               | 400 000          | 2021-2023                      | ХХБАБТХ                         |
| 2. |                                                            | Аюулгүйн тууз татах                                                                       |                            | 100 м               | 10000               | 1 000 000        | 2021-2023                      |                                 |
| 3. | Хийн тоног төхөөрөмжийн буруу сууриулалт                   | Технологийн заавар, аюулгүй ажиллах журмыг нарийн мөрдөх, Галын аюулаас сэргийлэх         |                            | Дотоод төлөвлөлтөөр |                     |                  | 2021                           |                                 |
| 4. | Шатах тослох материалын асгаралт                           | Машин зогсоох талбайг хайргажуулан нягтруулах                                             |                            |                     |                     |                  | 2021-2025                      |                                 |
| 5. | Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлтийн явцад учрах эрсдэл | Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын сургалт хийх. |                            | 10                  | 10000               | 1 000 000        | 2021-2025                      |                                 |
| 6. |                                                            | Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт, устгалд хяналт тавих.                     |                            | 8                   | 50000               | 300 000          | 2021-2025                      |                                 |
| 7. | Химийн бодисын ашиглалтаас үүсэх болзошгүй эрсдэл          | Химийн хорт болон аюултай бодисын тооллого хийх.                                          |                            | 10                  | 30000               | 300 000          | 2021-2025                      |                                 |
| 8. |                                                            | Ажлын байранд ашиглаж байгаа химийн бодисуудын ХАЛМ-ийг ажлын байрнуудад байрлуулах       |                            | 30                  | 10000               | 300 000          | 2021-2025                      |                                 |
|    | Нийт                                                       |                                                                                           |                            | 3 300 000           |                     |                  |                                |                                 |

## 8.ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлыг бууруулах үр дүнтэй арга техникийг ашиглах замаар хог хаягдлын хэмжээг бууруулах нь төслийн нэг хэсэг юм. Хог хаягдлыг боловсруулах, устгах чиглэлээр стандартад нийцэхийн тулд дахин ашиглах, боловсруулан ашиглах үйл явцыг хэрэгжүүлэх нь нэн тэргүүн чухал байна. Үүнд:

- Үйлдвэрлэлийн явцад сав, баглаа боодлыг (жишээ нь хуванцар сав) устгах замаар хог хаягдлыг багасгах
- Ахуйн хог хаягдлыг бууруулах, боловсруулан дахин ашиглах зэрэгт чиглэгдсэн ажилчдад мэдлэг олгох кампанит ажлыг хэрэгжүүлэх



## 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Шохойн чулуу олборлолтын ажлаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж ашиглалтын бүсийн болон түүний нөлөөллийн бүсийн талбайг хамран байгаль орчны орон нутгийн чанартай мониторингийн хяналтын систем байгуулах нь зүйтэй байна. Тухайн бүсэд хамрагдах объектуудын экологи ариун цэврийн нөхцлийг харгалзан:

- Ердийн хяналт шинжилгээний бүс
- Онцгой хяналт шинжилгээний бүс гэсэн 2 бүсэд ашиглалтын орчмын талбайг зааглан үзвэл зохино.
- Онцгой хяналтын бүсэд уурхайн ашиглалтын талбайг багтаан үзнэ дээрхээс бусад ашиглалтын ерөнхий нөлөөллийн хүрээнд орших задгай талбайг ердийн хяналтын бүсэд багтаан үзнэ.

## **1. Агаарын бохирдол**

- Хяналт шинжилгээ явуулах үзүүлэлт: Ажлын байрны агаар дахь тоосжилт болон бусад үзүүлэлтүүд
- Хяналт шинжилгээний төрөл, хэлбэр: Сорьц авч шинжилгээ хийх
- Байршил: Уурхайн орчмын цэгүүдээс

Мэргэжлийн байгууллагатай хамтран жилд 2 удаа шинжилгээ хийлгэх

### **Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ**

- MNS 0012-013:91. Ажлын бүсийн агаар. Эрүүл ахуйн шаардлага
- Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 4585 :2007
- Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага, MNS 5885 : 2008
- MNS 5002:2000. Чимээ шуугиан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр. Чимээ шуугианы хэм хэмжээ болон аюулгүй байдлын ерөнхий шаардлага
- MNS 4990:2000. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага

## **2. Хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол**

- Хяналт шинжилгээ явуулах үзүүлэлт-Хөрсний геохимийн үзүүлэлт, бохирдолт
- Хяналт шинжилгээний төрөл, хэлбэр

Ашиглалтын хугацаанд хөрсний геохимийн үзүүлэлтийг жилд хоёр удаа шинжлүүлэх

10. БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН  
ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8

| №   | Авах арга хэмжээ                                                                                                                                                        | Хугацаа, давтамж | Урьдчилсан зардал,төг  | Хамтран хэрэгжүүлэгч              | Гарах үр дүн                                                                                                                                                                                                                                                                                                         |
|-----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------|------------------------|-----------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1   | Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар ажил эхлэхийн өмнө сургалт, сурталчилгааг хийх | Жил бүр          | 400 000                | Мэргэжлийн байгууллага            | Ажилчдын байгаль орчны боловсролыг дээшлүүлж, хувь хүнээс үүдэлтэй бохирдол, аливаа гэмтэл ослыг бууруулах                                                                                                                                                                                                           |
| 2   | Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбар гаргаж, шинэчилж байх                  | Жил бүр          | 400 000                |                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| 3   | Гал тогооны хэсэгт ажиллах хүн бүрийг жилд 2 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах                                                                    | Хагас жилд       | 200 000                |                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| 4   | Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөр хамгаалал, хориглосон үйл ажиллагааны таниулах самбар байгуулах                                    | Жил бүр          | 400 000                |                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| 5   | Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах                                                                                                                    | 2 жил тутамд     | дотоод төлөвлөлтөөр    | Дүүргийн онцгой байдлын хэлтэс    | Гал түймрийн аюул, эрсдэлээс бүрэн сэргийлэх                                                                                                                                                                                                                                                                         |
| 6   | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлтийн тайланг боловсруулахдаа байгаль орчны мэргэжлийн байгууллагын зөвлөгөө авах                                      | Жил бүр          | 1 000 000              | БОННУ хийх мэргэжлийн байгууллага | Байгаль орчны удирдлагын тогтолцоо, нийгмийн хариуцлага болон эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, ирээдүйд гарч болзошгүй байгаль орчны эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг тодорхойлох, тэдгээрийн арилгах арга хэмжээ авах замаар учирч болзошгүй алдагдал, хохирлоос сэргийлэхэд чиглэсэн дүгнэлт, зөвлөмж авах |
| 7   | Байгаль орчны аудит хийлгэх                                                                                                                                             | 2 жил тутамд     | Харилцан тохиролцсноор | БОА хийх мэргэжлийн байгууллагууд |                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| Дүн |                                                                                                                                                                         |                  | 2 400 000              |                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                      |

Activate 1

11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ  
ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Хүснэгт 9

| # | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагаа                            | Тайлан мэдээлэл хүлээн авах тал                           | Тайлагнах хэлбэр                                   | Тайлгнах огноо           | Нийт зардал мян.төг | Хэрэгжүү - лэгч       | Хамтран хэрэгжүү -лэгч        | Биелэлтийн шалгуур                                                                       |
|---|----------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------|----------------------------------------------------|--------------------------|---------------------|-----------------------|-------------------------------|------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан                                               | БОАЖЯам, Аймгийн БО-ны газар, Сумын байгаль орчны ажилтан | Бичгээр                                            | 11 сарын 01-нд           | -                   | "Иннова Ложистик" ХХК | -                             | Аймгийн БО-ны газраар дүгнэлт гаргасан, тайлан дүгнэлтийн хамт БОАЖЯ-д хүргэгдсэн байна. |
| 2 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хагас жилийн тайлан                                                | Аймгийн БО-ны газар, Сумын байгаль орчны ажилтан          | Бичгээр                                            | 07 сарын 20-ны дотор     | -                   |                       | -                             | Холбогдох газарт тайлан хүргэгдсэн байна.                                                |
| 3 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн сар бүрийн хэмжилтийн мэдээлэл                                     | Компанийн удирдлагууд                                     | И-мэйл                                             | Сар бүрийн эхний 5 хоног | -                   |                       | -                             | Холбогдох талд сар бүр тайлан хүргэгдсэн байна.                                          |
| 4 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сар бүрийн биелэлт, БО-ны багийн үйл ажиллагааны тайлан         | Компанийн удирдлагууд                                     | И-мэйл                                             | Сар бүрийн эхний 5 хоног | -                   |                       | -                             | Холбогдох талд сар бүр тайлан хүргэгдсэн байна.                                          |
| 5 | Нөлөөллийн бүсийн иргэдийг Байгаль орчны мониторингийн ажилд оролцуулах, хэмжилтийн мэдээлэл танилцуулах | 1-р багийн иргэд                                          | Танхимын мэдээлэл ба хээрийн хэмжилтэнд оролцуулах | 10 сарын 20              | -                   |                       | Орон нутгийн харилцаа -ны баг | Жилд 1 удаа зохион байгуулагдсан байна.                                                  |

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД  
ТУСГАСАН ТӨСӨВ**

Хүснэгт 10

| № | ТӨЛӨВЛӨГӨӨ                                                              | ЗАРДЛЫН<br>ХЭМЖЭЭ | ТАЙЛБАР                                                                                            |
|---|-------------------------------------------------------------------------|-------------------|----------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга<br>хэмжээ                               | 2 400 000         | Дархан-Уул аймгийн<br>БОАЖГ-тай хамтран<br>ажиллах                                                 |
| 2 | Дүйцүүлэн хамгаалах зардал                                              | 3 000 000         |                                                                                                    |
| 3 | Орчны тохижилт, ногоон<br>байгууламжийг нэмэгдүүлэх ажлын<br>төлөвлөгөө | 1 900 000         | Ногоон бүсийг<br>нэмэгдүүлэхэд 1500-<br>2500 ширхэг мод<br>тарих                                   |
| 4 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга<br>хэмжээний төлөвлөгөө               | 1 000 000         |                                                                                                    |
| 5 | Осол, эрсдлийн менежментийн<br>төлөвлөгөө                               | 1 300 000         |                                                                                                    |
| 6 | Хог хаягдлын менежментийн<br>төлөвлөгөө                                 | 1 350 000         |                                                                                                    |
| 7 | Удирдлага зохион байгуулалтын<br>менежментийн төлөвлөгөө                | 1 400 000         | Байгаль орчны аудит<br>хийлгэх<br>Газрын хянан<br>баталгааны дүгнэлт<br>хийлгэх зардал<br>нэмэгдэх |
| 8 | Орчны хяналт шинжилгээний<br>хөтөлбөр                                   | 1 860 400         | Дархан-Уул аймгийн<br>УЦУОШТөвтэй<br>хамтран                                                       |
|   | <b>Нийт</b>                                                             | <b>10 210 400</b> |                                                                                                    |